

## “ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЦЭЦЭРЛЭГ”-ИЙН ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХООЛ ХҮНСНИЙ ЧАНАР

*А. Оюунбилэг, магистр, МУБИС*

**Abstract:** In 2012-2016, Mongolia implemented the “Child-friendly local program” among six kindergartens from Nalaikh district, Ulaanbaatar and fifteen kindergartens from various sums /territorial administrative unit of Mongolia/ of Khuvsgul province by UNICEF supported by Mongolian Government. The main objective of this program was to train and maintain child-friendly activities in selected kindergartens. During the implementation of this program we needed to take an external evaluation on child health and nutrition quality of child-friendly kindergartens and assessed in January-March 2015. Through this assessment child health, nutrition quality was analyzed comprising two hundred forty six parents, twenty eight cooks, sixteen accountants and other early childhood educators and providers.

In this paper, we introduce the purpose, objectives of the assessment and some interesting research results of this assessment by three aspects such as (1) parents’ satisfaction about their child’s health and activities organized by kindergarten, (2) food quality and supply in kindergarten and finally (3) quality of kitchen’s equipment and larder.

During the implementation of the project, aimag and soum and district administration, policy makers, teachers and parents from «child-friendly kindergartens changed their perceptions and attitudes towards the above issues. They developed recommendations and bulletins and The Board of Representatives in each district proved the «child-friendly» strategy for the implementation stage. The major outcomes of the project were successfully implemented in the kindergartens and household as well. For example: while improving the inter-sectoral coordination, the diseases among children decreased. Some kindergartens employed full-time doctors to develop collaboration among medical schools and kindergartens. Furthermore, kitchen and garden equipment were upgraded to improve drinking water, and restroom issues.

**Түлхүүр үгс:** хүүхдийн өвчлөл, эрүүл мэндийн байдал, хоол хүнс, ханган нийлүүлэлт, хадгалалт

### Удиртгал

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сан нь 1996 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүн амын нутаг суурьшлын хөтөлбөртэй хамтран “Хүүхдэд ээлтэй хот” санаачлагыг эхлүүлж, үүнээс хойш хүүхдийг орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн цөмд авч үзэж байгаа нь олон талт хамтын ажиллагааны эхлэл болсон (Дэлхийн хүүхдийн байдал, 2012, х. 89).

Монгол улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сан хамтран 2012-2016 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Хүүхдэд ээлтэй орон нутаг” төсөлд нийслэлийн Налайх дүүрэг болон Хөвсгөл аймаг сонгогдон амжилттай хэрэгжиж байна.

Хэрэгжилтийн явцад зорилтот цэцэрлэгүүд хүүхэд бүрт ээлтэй үйлчилгээг үзүүлж байгаа эсэхэд хийсэн өөрийн үнэлгээний тайланд хөндлөнгийн үнэлэлт дүгнэлт өгөх хэрэгцээ урган гарсан юм.

Энэ зорилгоор үнэлгээний ажлын хэсэг тухайн орон нутгийн зорилтот цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай танилцаж хэрэгжилтийн

явцад мониторингийн үнэлгээ хийсэн билээ. Судалгаагаар “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг”-үүдийн “Хүүхдийн эрүүл мэнд, хоол хүнсний байдал”-г судалсан ба судалгааны дүнг танилцуулж байна.

Судалгааны баг судалгаанд оролцуулах цэцэрлэгүүдийг газар зүйн байршил, алслагдсан байдал, хүн амын нягтрал, багш хүүхдийн тоо, өөрийн үнэлгээний дүн зэрэг шалгуурыг баримтлан Налайх дүүргийн 6, Хөвсгөл аймгаас Мөрөн сум, Цагааннуур, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Арбулаг, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Түнэл, Тосонцэнгэл, Их-Уул, Тариалан сумын 15, нийт 21 цэцэрлэгийг сонгон судалгаа хийсэн.

Судалгааг баримт бичгийн анализ, чанарын судалгаа (Налайх дүүрэг, Хөвсгөл аймгийн цэцэрлэгүүдийн хоолны цэс, ханган нийлүүлсэн хүнсний бүтээгдэхүүний жагсаалтад анализ хийн, тогооч, няравтай фокус бүлгийн ярилцлага, кейс судалгаа, ажиглалтын арга, ганцаарчилсан ярилцлага) хийж боловсруулалтыг SPSS-20 программыг ашиглан гүйцэтгэлээ.

**Судалгааны явц**

**I. Хүүхдийн эрүүл мэндийн байдал, цэцэрлэгээс явуулж буй ажилд эцэг, эхийн сэтгэл ханамж**

1. Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 36 дугаар тогтоолоор баталсан 2014 -2016 оны “Хүүхдэд ээлтэй” стратегийн зорилт 1-ийн Үйл ажиллагаа 1.8 –д Хүүхдийн цэцэрлэгүүдэд мэргэжлийн эмч ажиллуулах бодлого боловсруулж хэрэгжүүлэхээр төлөвлөсний дагуу аймгийн төвийн цэцэрлэг болон зарим сумын цэцэрлэгт эмч ажиллаж байгаа ба сумдын эмчгүй цэцэрлэгүүдийн эрүүл мэндийн асуудлыг сургуулийн эмч давхар хариуцан ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газраас захирамж гарган аймгийн төв болон сумдын сургууль цэцэрлэгийн хүүхдийн өвчлөлийн байдлын мэдээг 7 хоног тутам авч өвчний гаралт, дэгдэлтийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлж халдвар тархалтыг хязгаарлан ажилласнаар өвчлөл багассан байна.

Цэцэрлэгийн эмч нар өдөр бүр бүлгүүдэд ажиглалт үзлэг хийн, өвдсөн хүүхдийг үзлэгт хамруулан Эрүүл мэндийн яамны сайдын 2013 оны 450 тоот тушаалаар баталсан бүртгэлийн маягт АМ -1А-ээр бүртгэж, шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг байна.



2. Судалгаанд хамрагдсан цэцэрлэгүүд тодорхой ажлыг зохион байгуулж байгаа боловч түгээмэл ажиглагдаж буй өвчлөл бол шүдний өвчлөл байна. Аймаг болон сум дундын эмнэлэгт шүдний эмч ажилладаг. Харин сумдад шүдний эмч байхгүй учир эмчилгээ, оношилгоо хийлгэхэд хүндрэлтэй байдгаас шүдний өвчлөл нийт хүүхдийн 46-80%-г хамарч эрүүл мэндийн тулгамдсан асуудал болжээ.

3. Налайх нь Улаанбаатар хотын нэг дүүрэг (одоо хот) гэдэг утгаараа багш ажилчид мэдээллийг түргэн авах, сургалт семинарт оролцох боломжтой. Багш, ажилчид 9-р сард эрүүл мэндийн шинжилгээ хийлгэх, сар бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, хүүхэд бүр эрүүл мэндийн хяналтын дэвтэртэй зэрэг давуу тал нь өвчлөл бага байхад эерэг нөлөөтэй байна.

4. Налайх дүүргийн эцэг эхчүүд танай хүүхэд цэцэрлэг дээрээ эрүүл мэндийн ямар

үйлчилгээ авдаг вэ? гэсэн асуултад 11,6 хувь нэмэгдэл хоол тэжээл, 24,6 хувь эрүүл мэндийн зөвлөгөө, 63,8% нь эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг гэсэн хариулт өгсөн байна. Хөвсгөл аймгийн эцэг эхчүүдийн 81,3% нь эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг, 16,9% нь цэцэрлэг дээрээ эрүүл мэндийн зөвлөгөө авдаг, 1,9% нь нэмэгдэл хоол тэжээл авч байсан гэж хариулсан байгаа нь үйлчилгээнд сэтгэл хангалуун байна.

Диаграмм 1  
Хүүхэд эрүүл мэндийн үйлчилгээ (Налайх, Хөвсгөл аймаг)



**II. Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний хангамж, чанар.**

1. Цэцэрлэгүүд хоолны цэсийг Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яамнаас гаргасан зөвлөмжийн дагуу (Цэцэрлэгийн хоолны цэс зөвлөмж, 2009, х.5,6) 7-14 хоногоор төлөвлөдөг байна.

2. Хоолны цэсийг үндэслэн хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэхдээ Эрүүл мэндийн сайдын 2014 оны 04 сарын 08-ны өдрийн 113

тоот тушаалын хавсралтын дагуу хоногт хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг баримталдаг байна.



3. Сургуулийн өмнөх нас нь хүний хөгжлийн хамгийн эрчимтэй нас бөгөөд тэжээлийн бодис хангалттай, зохистой харьцаатай байхгүй бол бие махбодын нэг юмуу хэд хэдэн хэсэг тухайлбал хөл нь богино, цээж нь урт, ходоодны хэмжээ бага гэдэс нь урт болж эрхтэн систем эмгэг байдалд хүрч тэнцвэргүй өсч хөгждөг (БСШУЯ, 2009). Мөн амьдралын эхний жилүүдэд хэрэглэсэн энергийн 50-75% нь тархины хөгжилд зарцуулагддаг (НҮБХС, 2014).

Цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хоолны цэст анализ хийж үзэхэд хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, найрлагад анхаарах, хүүхдийн өсөлт хөгжилд шаардлагатай кальци, бусад амин дэм, бичил тэжээлийн бодисыг агуулсан хүнсийг зөвлөмжийн дагуу хэрэглэх шаардлагатай байна.

4. Эцэг эхчүүд цэцэрлэгийн хоол хүнсэнд хэр зэрэг сэтгэл хангалуун байдгийг тандах зорилгоор авсан судалгааны “Таны хүүхэд цэцэрлэгтээ эрүүл хоол хүнс хэрэглэж чадаж байна уу?” гэсэн асуултад судалгаанд оролцсон Налайх дүүргийн эцэг эхчүүдийн 47 буюу 68% нь “тийм”, 20 буюу 28,9% нь тийм боловч сайжруулах шаардлагатай 2 буюу 2,8% нь мэдэхгүй гэж хариулсан бол Хөвсгөл аймгийн эцэг эхчүүдийн 126 буюу 75% нь тийм, 36 буюу 18% нь тийм боловч сайжруулах шаардлагатай, 12 буюу 7% нь мэдэхгүй гэж хариулжээ.

Диаграмм. 2

Эцэг эхчүүдийн цэцэрлэгийн хоол хүнсний үйлчилгээний сэтгэл ханамж




“Хүүхдийн хоол хүнсний чанарыг сайжруулахын тулд шийдвэрлэх асуудлыг тодорхойлно уу?” гэсэн асуултад “Хүүхдийг амин дэм эрдэс бодисоор баялаг хоол хүнсээр хангах хэрэгтэй” гэж Налайх дүүргийн эцэг эхчүүд 92%, харин энэ асуултад Хөвсгөл аймгийн эцэг эхчүүдийн 90% нь хариулсан байна.

### III. Гал тогооны тоног төхөөрөмж, хүнсний агуулах

1. Хүнсний агуулахын хувьд өөрийн боломжинд тохируулан тохижуулсан өрөө, болон гадаа агуулахад хуурай буюу савласан хүнсийг тусгай тавиур дээр, гурил будааг лаазанд, махыг хөргөгчинд хадгалж байлаа. Орон нутгийн боломж, нөхцөлдөө тохируулан засч сэлбэх, шинээр барих ажлыг энэ хугацаанд гүйцэтгэсэн байна. Гэсэн хэдий ч хүнсний бүтээгдэхүүнийг аюулгүй хадгалах тал дээр аймаг, дүүрэг, сумын удирдлага илүү анхаарч, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх шаардлагатай байна. Үүнийг цэцэрлэгүүдэд ажиллаж байгаа нярав, тогооч нараас авсан асуулгын дүн харуулж байна.

Диаграмм 3. Нярав, тогооч нараас авсан “Хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан агуулах, сав суулга хүрэлцээ”-ний байдал





2. Налайх дүүргийн цэцэрлэгүүдийн гал тогооны тоног төхөөрөмж шинэчлэгдсэн байна. Хөвсгөл аймгийн хувьд цэцэрлэгүүдийг гал тогооны цахилгаан хэрэслээр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөн шинэчилж байна. Цэцэрлэгүүдийн гал тогооны тоног төхөөрөмжийг бүрэн болон хэсэгчлэн шинэчилж байгаа боловч цахилгаан утасны монтаж, аюул осолгүй талаас нь анхаарах шаардлагатай байна.
3. Зарим хуучин барилгуудад гаднаасаа дотогшоо урсгал, хоол хүнсийг бэлтгэх, боловсруулах, хадгалах, түгээх ажиллагааны нөхцөл, эрүүл ахуйн шаардлага хангалтгүй байна.
4. Налайх дүүргийн хэмжээнд хүнсний бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийг тендерээр шалгарсан “Хүнс хангамж” Төрийн бус байгууллага (ТББ) хангадаг. Тендерээр шалгарсан байгууллагаас хүнс нийлүүлэх үйл ажиллагаанд дүүргийн Мэргэжлийн хяналтын газар хяналт тавьж ажилладаг байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд хүнсний бүтээгдэхүүнийг тендерээр шалгарсан байгууллага ханган нийлүүлж байгаа ба хяналт шалгалтыг гадна болон дотроос нь хийдэг. Тендерийн шалгуур, шаардлагыг жил бүр цэцэрлэг комисс гарган бүтэн жилийн хэрэгцээгээ тодорхойлон үнийн төсөвтөө баримжаалан захиалгын хэмжээ, шалгуурын хамт тендер шалгаруулах газар өгч ханган нийлүүлэгч байгууллагыг шалгаруулдаг. Захиалгыг сараар, өдрөөр хийдэг ба зарим цэцэрлэг хүнсний бүтээгдэхүүнийг 3 багц болгон 2-3 байгууллагаас авдаг.

5. Ханган нийлүүлэх үйл ажиллагаа эрх зүйн хүрээнд явагдаж, хяналт шалгалт хийгдэж байгаа боловч сайжруулах асуудал байна. Зарим тохиолдолд чанарын шаардлага хангаагүй хүнсийг шинжилгээнд өгөх хэрэгцээ байдаг боловч төсөв мөнгө байдаггүй.
6. Хот, аймгаас хол сумын цэцэрлэгүүд хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, аюулгүй байдал, малын гаралтай хүнсний баталгаажилт тодорхойгүй байна.

### Судалгааны үр дүн

Өнгөрсөн хугацаанд “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” төслийн хүрээнд орон нутгийн удирдлага, цэцэрлэгийн хамт олон, эцэг эх дээрх асуудлыг ажлын төлөвлөгөөндөө тусган үе шаттайгаар шийдвэрлэсэн нь судалгаагаар харагдаж байлаа.

Судалгаа хийхээс өмнө 2014 оны 9 дүгээр сард Хөвсгөл аймгийн хүүхдийн цэцэрлэгийн 260 гаруй багштай “Сургуулийн Өмнөх Боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн эрүүл мэндэд тулгамдаж буй асуудал” сэдвээр уулзалт, ярилцлага зохион байгуулсан. Уулзалт, ярилцлагын явцад багш нар аймаг, сумдын хүүхдийн цэцэрлэгүүдэд түгээмэл тохиолдож буй доорх сэдвийг хөндсөн юм. Үүнд:

- Орон нутгийн хүүхдийн цэцэрлэгүүд гүнийн худгийн ус хэрэглэдэг бөгөөд энэ ус нь хангах эсэх нь тодорхой бус.
- Ханган нийлүүлж буй хүнсний нэр төрөл, махны баталгаат чанар тодорхойгүй (үзлэгт хамрагдсан, вакцин хэдийд хийлгэсэн, эрүүл эсэх гэх мэт). Хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын агуулах, зоорь орчин үеийн стандартад нийцээгүй.
- Сум, орон нутагт хүүхдийн нарийн мэргэжлийн эмч, шүдний эмч байхгүй, лабороторийн шинжилгээ хийдэггүй. Цэцэрлэгийн багш, ажилчид хичээлийн жил эхэлснээс хойш аймгийн төвд ирж эрүүл мэндийн шинжилгээ хийлгэдэг зэрэг нь хүүхдийн дунд өвчин тархах, өвчилсөн тохиолдолд хүндрэх, архагших улмаар амьдралын чанарт нөлөөлөх эрсдэлтэй хүчин зүйл байгааг залруулах, үйл ажиллагаа болгох гарцыг хайн хэлэлцсэн юм.

## ДУГНЭЛТ

- Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн асуудал нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж байгаа өнөө үед хүүхдэд эрүүл ахуйн дадал төлөвшүүлэх, эрүүлжүүлэх, зохистой хооллох, эрүүл мэндийн боловсролын түвшин, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд салбар дундын үйл ажиллагааг чиглүүлэх. Судлаачдын үзэж байгаагаар шүдний өвчний шууд болон шууд бус нөлөөллөөр хоолой өвдөх, зүрх судасны өөрчлөлт, ходоод гэдэс, бөөр үрэвсэх зэрэг олон төрлийн өвчин үүсдэг бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд ихсэж байгааг анхаарах.
- Хүүхдийн өсөлт хөгжил эрчимтэй явагдаж, илчлэг, тэжээллэг бодисын хэрэгцээ илүү шаардлагатай байдаг хөгжлийн суурь энэ насанд зохистой хооллох талаар эцэг, эх, тогооч, нярав, эрхлэгч, засаг дарга, ханган нийлүүлэгч байгууллага шат шатандаа анхаарах.
- Шинжлэх ухаан технологийн эрчимтэй бөгөөд үсрэнгүй хөгжил, хүнсний бүтээгдэхүүний цэвэр экологийн байдал багасч тогтворжуулагч, хадгалалтыг уртасгагч, амт оруулагч бодис нэмэх болсон, тэдгээрийн хил хязгааргүй урсгал, хяналтын системийн хоцрогдол, хүн амын боловсролын түвшин, байгалийн бохирдол зэрэг олон хүчин зүйлийг харгалзан хоол бэлтгэлийн шат дамжлага бүрийн технологийн шаардлага, норм, норматив, стандартын хэрэгжилтэд илүү анхаарах. Үүнд: “Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэх, Ерөнхий шаардлага” MNS 5343:2003, Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгонд тавигдах ерөнхий шаардлага” MNS САС 1:2007, “Хүнсний агуулах” MNS 5364:2011, Хоол үйлдвэрлэлийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавигдах ерөнхий шаардлага” MNS 5078:2001 болон бусад стандартын хэрэгжилтэд тавих дотоодын хяналтаа сайжруулах.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Боловсрол шинжлэх ухааны яам. (2014). *Боловсролын салбарын 2013-2014 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхэтгэл* (1). Улаанбаатар.
- Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Нэгдсэн үндэсний байгууллага, (2009). *Цэцэрлэгийн хүүхдийн зохистой хооллолтын зөвлөмж*. Улаанбаатар.
- Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн. (2009). *Цэцэрлэгийн хоолны цэс*. Улаанбаатар.
- Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сан. (2015). *Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үзэл баримтлалын хэрэгжилт мониторинг. Тайлан*. Улаанбаатар: GZ press
- Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сан. (2012). *Дэлхийн хүүхдийн байдал*. Улаанбаатар
- Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль. (2012). *Нийгмийн эрүүл мэндийн хоол судлал*. Улаанбаатар:
- Энхтүвшин, С., Болормаа, З., Дуламжав, Г. (2013). *Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээ*. Улаанбаатар.
- Save the children. (2014). *Child-friendly kindergarten project evaluation (Report)*. Ulaanbaatar.
- Монгол улс. *Сургуулийн Өмнөх Байгууллагын 2014-2015 оны статистик мэдээ* // <http://www.meds.gov.mn/>